



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

до24 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 8/4

Улаанбаатар хот

### Г Унэлгээний хороог шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн 2024 оны лабораторийн оношлуур, урвалж худалдан авах ажиллагааны тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үнэлгээний хорооны дарга: О.Сансар (Санхүү, хангамж, нөөцийн албаны Аж ахуйн менежер)

Гишүүд: Б.Батцэцэг (Ариутгал халдвартгүйтгэл, биоўйлдвэрлэлийн албаны Биотехнологич)

Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи, инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн)

Б.Анудар (Худалдан авах ажиллагааны хөтөч ТББ-ын Нягтлан бодогч)

Нарийн бичиг: Б.Номин-Эрдэнэ (Санхүү, хангамж, нөөцийн албаны Эдийн засагч)

2. Тендерийн баримт бичгийг холбогдох хууль, журмын дагуу боловсруулан гүйцэтгэгч сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хорооны дарга (О.Сансар)-д үүрэг болгосугай.

3. Тендерийн сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгүүдийг цэгцэлж архивын нэгж бүрдүүлэх, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, шилэн данс, худалдан авах ажиллагааны цахим сайтад мэдээлэл байршуулан ил тод байдлыг ханган ажиллахыг Үнэлгээний хорооны Нарийн бичиг (Б.Номин-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан төвийн Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгчийн 2024 оны А/05 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.АМГАЛАНБАЯР

